



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/54

Мандалговь

Г Хурдан морины уралдаан  
зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн А/36 дугаар тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын 3.10.2, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, Хүний эрхийн үндэсний комиссын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/10 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалга найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

Хоёр. Өвөл хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, ялангуяа уяачид, эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх сумдын Засаг дарга, “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбоо (Ц.Ганхүү), сумдын Морин уяачдын холбооны тэргүүн нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд онцгой хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Бумангэрэл), тайлан нэгтгэн тухай бүр танилцуулж байхыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Аймгийн Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн А/63 тоот “Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488910159